



“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК

Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилтийн явц:

Нийслэлийн 2022 оны төсөвт 2474,1 сая төгрөг тусгагдаж гүйцэтгэгчээр “Энх өглөө” ХХК нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан тус ажлыг гүйцэтгэсэн. Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний А/206 дугаар тушаалын дагуу Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж шугамыг ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х17мВА чадалтай үндсэн дэд станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд: Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х17мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн.

Гүйцэтгэгчээр “Эм Ай Эс Эс” ХХК нь шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 гэрээ байгуулсан. Дэд станцын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажил эхлэх зөвшөөрлийг холбогдох байгууллагад хүргүүлсэн хүлээгдэж байна. Мөн техникийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулан хүсэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдөр ЭХЯ-д хүргүүлсэн.

Мэдээлэл өгөх ажилтан:
Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын
газрын дарга Б.Мөнгөнхуяг.
Утас: 88656964